



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2014 оны А/71 дүгээр тушаалын Лхагваа овогтой Төрмөнхөд холбогдох хэсгийн “Австрали Улсын Ла Троби /La Trobe/ Их сургуульд” гэснийг “Австрали Улсын Монаш /Monash/ их сургуульд” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2014 оны А/53 дугаар тушаалын Бадамцэрэн овогтой Баттүвшинд холбогдох хэсгийн “Канадын Иорк Их сургууль” гэснийг “АНУ, Канзасын Парк Их сургууль” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР